

***Томуугийн цартахлын бэлэн байдал, хариу арга хэмжээний удирдамж батлах тухай ЭМС-ын 2018 оны А/438 тоот тушаал***

***А. БУРМАА, АУ-ы доктор (Ph.D)  
ХӨСҮТ, ТҮТ***

***Хавсралтууд***

- 1. Томуугийн цартахлын бэлэн байдал, хариу арга хэмжээний удирдамж***
- 2. Томуугийн цартахлын бэлэн байдал, хариу арга хэмжээ (2018-2022)***
- 3. Томуугийн цартахлын вирус халдварын тархварзүйн судалгааны хуудас***

## *Зорилго*

Томуугийн цартахал болон шинэ вируст халдвараас сэргийлэх, хариу арга хэмжээний бэлэн байдлыг ханган хохирол багатай даван туулах арга хэмжээг зохион байгуулах

## *Зорилт*

- 1. Томуугийн тандалтын тогтолцоог бэхжүүлэх, томуугийн цартахал болон шинэ вируст халдварыг шуурхай илрүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийх, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, нотолгоонд суурилсан шийдвэр гаргах*
- 2. Цартахлын үеийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг ханган, тасралтгүй хүргэх, эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлэх*
- 3. Цартахлын үед хүн амыг цартахлын вакцинаар шуурхай дархлаажуулах, хүн ам, иргэдийн оролцоог дэмжих замаар халдвараас урьдчилан сэргийлэх, тархалтыг бууруулах, хязгаарлах*
- 4. Хүн ам, ард иргэдийг үнэн зөв, бодит мэдээллээр шуурхай хангах*

## *Томуугийн болзошгүй цартахал*

ЭМС-ЫН 2018 оны А/438 тоот тушаал

1. Томуугийн цартахал хоорондын үе
2. Томуугийн цартахлын түгшүүр үе
3. Томуугийн цартахлын үе
4. Томуугийн цартахлын дараах үе

## Томуугийн цартахал хоорондын үе

- ✓ Томуугийн харуулдан тандалтыг тогтмол хийх
- ✓ Томуугийн үндэсний зөвлөлгөөнийг жил бүр зохион байгуулах
- ✓ Томуугийн харуулдан тандалтын үнэлгээний журмыг тухай бүр шинэчлэн үнэлэх
- ✓ Лабораторийн бэлэн байдлыг ханган ажиллах
- ✓ Лабораторийн гадаад, дотоодын чанарын хяналтыг тогтмол хийх
- ✓ Сургалт, сурталчилгааны материал боловсруулах, түгээх
- ✓ Эрсдэлт бүлгийн хүн амыг томуугийн вакцинаар дархлаажуулах
- ✓ Тамифлю болон вирусийн эсрэг эмийн нөөцийн тооцоог гаргах
- ✓ Гахай, шувуу аж, ахуй эрхлэгчдийн судалгааг жил бүр шинэчлэх
- ✓ Эрчимт эмчилгээ, сэхээн амьдруулах тусламж үйлчилгээнд шаардагдах багаж, тоног төхөөрөмжөөр үе шаттай хангах

## ***Үргэлжлэл***

- ✓Томуугийн эмнэлзүйн удирдамж, гарын авлага, зааврыг шинэчлэх
- ✓Томуугийн цартахлын үеийн бэлэн байдлыг хангах, хүний нөөцийн төлөвлөгөөг боловсруулах, жил бүр шинэчлэх
- ✓Үзүүлэх сургуулилт, ширээний дасгалыг бүсчлэн зохион байгуулах
- ✓Томуугийн цартахлын бэлэн байдлын үнэлгээ хийх
- ✓Эмнэлгийн шарил хадгалах байрын тохижуулах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх
- ✓Эрсдэлийн үнэлгээний багийг сургах, чадавхжуулах
- ✓Эрсдэлийн үеийн харилцаа холбооны гарын авлага боловсруулах, түгээх
- ✓Сорьц тээвэрлэх талаар тээврийн байгууллагатай гэрээ хийх

## ***Томуугийн цартахлын түгшүүр үе***

- ✓Цартахлын болон шинэ вируст халдварын мэдээллийг Засгийн газар болон ДЭМБ-д мэдээлэх
- ✓ТТӨ-ий өдөр тутмын мэдээлэлд дүгнэлт гаргах
- ✓Томуугийн лабораториудын үйл ажиллагааг үнэлэн, шаардлагатай арга хэмжээ авах
- ✓Сорьцийн тоог нэмэгдүүлж, шинжилгээг цаг тухай бүрд хийх
- ✓Ялгасан вирусийн төлөөлөл омгийг олон улсын томуугийн Лавлагаа төвд илгээх
- ✓Цартахлын вируст халдварын эсрэг вакциныг шуурхай түгээх, дархлаажуулах төлөвлөгөөг боловсруулах
- ✓Тамифлю болон вирусийн эсрэг эмийн нөөцийг бүрдүүлэх
- ✓Эмнэлзүйн удирдамжийг нөхцөл байдалтай уялдуулан шинэчлэх, сургалт зохион байгуулах
- ✓Бэлэн байдлын төлөвлөгөөг идэвхжүүлэн, тодотгол хийх
- ✓Сурталчилгааны материал гарган түгээх

## *Томуугийн цартахлын үе*

- ✓Цартахлын болон шинэ вируст халдварын мэдээллийг Засгийн газар болон ДЭМБ-д мэдээлэх
- ✓Бэлэн байдлын төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг зохион байгуулах
- ✓ТТӨ-ий өдөр тутмын мэдээлэлд дүгнэлт гаргах
- ✓Лабораториудын үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах
- ✓Ялгасан вирусийн төлөөлөл омгийг олон улсын томуугийн лавлагаа төвд илгээх
- ✓Цагийн байдлын талаархи бодит мэдээллийг цаг алдалгүй түгээх
- ✓Цартахлын вакцинаар эрсдэлт бүлгийн хүн амыг дархлаажуулах
- ✓Тамифлю болон вирусийн эсрэг эмийн хангалтыг нэмэгдүүлэх
- ✓Эрсдэлийн үнэлгээг хийж, эрсдэлийн түвшинд тохирсон арга хэмжээг зохион байгуулах

## *Томуугийн цартахлын дараах үе*

- ✓Цартахлын үед авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаанд үнэлгээ хийх
- ✓Бодлогын баримт бичгүүдийг шинэчлэх
- ✓Цартахлын болзошгүй дараагийн давалгааны бэлэн байдлын төлөвлөгөөг шинэчлэх

***АНХААРАЛ ХАНДУУЛСАН  
ТА БҮХЭНД БАЯРЛАЛАА***